




163 Page



164 Page



165 Page



166 Page



167 Page

Давид ба Ионатан

-David and Jonathan-

Тайлбарлагч Голиаттай тулалдаж түүнийг ялсан Давид Саул хааны ордонд амьдрах болжээ. Саул хаан Ионатан гэдэг хүүтэй байв. Удалгүй Ионатан Давид хоёр сайн найзууд болжээ. Нэгэн өдөр Ионатан Давидад ингэж хэлэв.

Ионатан “Миний сайн найз Давид, чи одооноос эхлээд миний хамгийн хайртай найз байх болно. Миний чамд өгч байгаа бэлгийг ав!

Тайлбарлагч Ионатан өөрийнхөө хамгийн өмсөх дуртай ханхүүгийн дээл болон сэлэм, нум сум, бүсийг найз Давиддаа бэлэг болгон өгчээ.

Давид “Хоёулаа өнөөдрөөс эхлэн хамгийн сайн найзууд болсон шүү”,
Ионатан “-Зал!”

Тайлбарлагч Ийнхүү Ионатан Давид хоёр үргэлж нэгнийхээ сайн найз байна гэж тангарга өргөжээ. Тэр хоёр бие биедээ туслан, халамжилж сайхан нөхөрлөл дунд өсөж байлаа.

Тайлбарлагч Нэгэн өдөр Саул хаан Давидын хамт дайнаас буцах үед гудамжинд ард түмэн дуулж байхыг сонсчээ.

Ард түмэн “Саул хаан мянгыг, Давид түмийг ялав”

Тайлбарлагч гэж дуулахыг сонсоод Саул хаан маш ихээр уурлажээ.

Саул хаан “Энэ ард түмэн надаас илүү Давидыг хайрладаг байх нь. Одоо яах билээ? Давид миний оронд хаан болчихвол яах вэ? Үгүй, болохгүй шүү! Израилийн хаан зөвхөн би л байх болно! Дараа нь миний хүү Ионатан хаан болох ёстой!

Тайлбарлагч Саул хаан сэтгэл нь тавгүйтэх үедээ Давидыг дуудан ятга тоглуулдаг байжээ. Түүний тоглох ятгын аялгууг сонсоод хааны сэтгэл нь сайхан болдог байв. Гэтэл нэгэн өдөр Давидын дуулахыг сонсож байсан Саул хаан гэнэт түүн уруу жад шиджээ. Давид маш хурдан бултаж амжжээ.

Давид “Саул хаан яагаад ингэх болов?”


Тайлбарлагч Давид, Саул хаан яагаад өөрт нь дургүй болсоныг ойлгохгүй байв. Үнэндээ Давидыг ард түмэн илүү ихээр хүндэлж байгааг хараад, Саулын уур нь хүрсэн аж. Тэрээр бүр илүүгээр Давидыг үзэн ядаж эхэлжээ.

Тайлбарлагч Саул хаан, Давидыг хөнөөхийг хүсэв. Үүнийг мэдсэн Ионатан Давидад их санаа зовжээ. Тэгээд аавдаа зориглон хэлэв.

Ионатан “Аав аа, яагаад миний найзыг алахыг хүснэ вэ? Давид Голиаттай тулалдаж ялсан шүү дээ. Тэр маш зоригтой, бас итгэмжтэй хүн шүү дээ”

Тайлбарлагч Саул хаан ихэд ичив. Тэгээд амлалт өгсөн

Саул хаан “Чиний үг зөв. Би түүнийг хөнөөхгүй” хэмээн амлав.



168 Page



169 Page



170 Page

Тайлбарлагч Гэтэл нэгэн өдөр Давидыг ятгаа тоглож байх үед нь Саул хаан дахиад жад шиджээ.Тиймээс Давид шөнөөр зугтав. Түүний зугтсаныг Саул хаан мэдчихэв.

Саул хаан “Давид хаана байна вэ?”

Ионатан “Тэр хол зугтаажээ”.

Тайлбарлагч Удалгүй Саул хаан өөрийн хүү Ионатан нь Давидыг зугтахад нь тусалсаныг мэдээд бүр ч их уурлажээ. Тэгээд тэр Давидын хойноос туслахуудаа явуулав.

Саул хаан “Давид хаана нуугдчихваа? Хурдан бариад түүнийг устгах хэрэгтэй!”

Тайлбарлагч Саул хаан Давидыг хөнөөх гэхэд нь Ионатан найзыгаа нэгэн хадны ард нуув.

Давид “ Ионатан, аав чинь яагаад миний амийг эрнэ вэ? Би ямар буруу юм хийсэн юм бэ?”

Ионатан “Давид аа, чи хэзээ ч үхэхгүй ээ. Хэрэв аав маань чамайг алах гэвэл би чамд тусалж зугтаалгах болно.”

Тайлбарлагч Саул хаан Давидыг үзэн ядаж хөнөөх гэж оролдож байсан ч Давид Ионатан хоёрын нөхөрлөл бат бэх байлаа. Ионатан Давидтай нууцаар уулздаг байв тэгээд давидад хандан

Ионатан “Давид аа, хурдан зугт. Аав чамайг үнэхээр алах гэж байна”

Тайлбарлагч гэж хэлээд тэр хоёр бие биенээ тэврэн уйлцгаав. Тэдний салах цаг болж Давид зугтжээ. Гэсэн хэдий ч тэр хоёр сайн найзууд хэвээр байлаа.